

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1.	Оршил	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	7
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11.	Шилэн дансны мэдээлэл	8
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
4.6	Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	20
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандар
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 29 ДҮГЭЭР
ТУСГАЙ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ М. САРАНТУЯА
ТАНАА

2019.02.25 № 06/308
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд 8.9.1-д заасны дагуу Ерөнхий боловсролын 29 дүгээр тусгай сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Ерөнхий боловсролын 29 дүгээр тусгай сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Ерөнхий боловсролын 29 дүгээр тусгай сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал


1. Бараа материалын дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгийн шинж чанартай 2,599.6 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрөлгүй акталсан.
 2. Эд хөрөнгийн тооллогын комисс томилохдоо Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх заалт “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.”, мөн тооллогын комисс тооллого явуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 зүйлийн 72.4 дэх хэсэг “комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх” гэсэн хэсгүүдийг тус тус зөрчсөн.
 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг дутуу хэрэгжүүлсэн.
 4. Санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасан цагалбарт хугацаанаас 19 хоног хугацаа хоцроож ирүүлсэн.
- зэрэг зөрчлүүд нь холбогдох хууль тогтоомж болон санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Ерөнхий боловсролын 29 дүгээр тусгай сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Ерөнхий боловсролын 29 дүгээр тусгай сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгч М. Сарантуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ерөнхий боловсролын 29 дүгээр тусгай сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ерөнхий боловсролын 29 дүгээр тусгай сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 18-ны өдрөөс 2019 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Гэрэлт хөхийн тэнцвэр аудит” ХХК-ийн аудитор В. Сэлэнгэ, аудиторовн туслах Ц. Аюушжав нар хариуцаж хэрэгжүүлэв.

Ерөнхий боловсролын 29 дүгээр сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-д 2019 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Ерөнхий боловсролын 29 дүгээр тусгай сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: Хүүхэд бүрийг хөгжүүлэх, бие даан сурах, ажиллах чадвартай, эрдэм мэдлэгтэй, өндөр чадамжтай иргэн болгон төлөвшүүлэхэд оршино

Ерөнхий боловсролын 29 дүгээр тусгай сургууль нь 2017-2018 оны хичээлийн жилийн зорилго зорилтын биелэлтийг дүгнэн хэлэлцсэн бөгөөд 2018-2019 оны хичээлийн жилд “Суралцагчдын сурлагын ахицыг нэмэгдүүлэх” зорилгыг нийт багш суралцагчид болон ажиллагсад таниулан үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж, “Эх хэлээрээ зөв ярьж бичиж сурцгаая” гэсэн зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл: Тусгай зөвшөөрлийн хавсралтанд заасан түвшний боловсрол эзэмшүүлэх сургалт

Ерөнхий боловсролын 29 дүгээр тусгай сургуулийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Ерөнхий боловсролын 29 дүгээр тусгай сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

1. Тусгай сургууль, цэцэрлэгүүд Нийслэлийн харьяанд байсан хэдий ч Боловсрол соёл шинжлэх ухаан спортын сайдын 2017 оны 05 дугаар сарын 11-ий А196 тушаалаар тус яамны харьяанд шилжсэн байна.

2. Захирал 2018 оны 08 дугаар сарын 30-ны өдөр түр орлон гүйцэтгэгчээр томилогдсон байна

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Ерөнхий боловсролын 29 дүгээр тусгай сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Ерөнхий боловсролын 29 дүгээр сургууль санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Ерөнхий боловсролын 29 дүгээр тусгай сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Ерөнхий боловсролын 29 дүгээр тусгай сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүү үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар сонгов.

Материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгосон нь байгууллагын үйл ажиллагааны ажлын бодит цар хүрээ хэмжээг илэрхийлж байгаа тул зохимжтой гэж үзэв.

Ерөнхий боловсролын 29 дүгээр тусгай сургуулийн 2018 оны нийт зардал 2,164,648.5 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 21,646.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь аудитын түүвэрт хамрагдаж байсан тул эрсдэлтэй гэж үзэн сонгосон болно.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 3 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 3 асуудалд зөвлөмж өгч, 2 асуудалд албан шаардлага хүргүүлсэн болно.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

/мянган төгрөгөөр/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	3,721.5	
2	Албан шаардлага өгсөн	2	1,606.00	
	Дүн	5	5,327.5	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дэх “төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлсэн байх” гэсэн заалтыг зөрчиж 2019 оны 02 дугаар сарын 13-ны өдөр ирүүлж 19 хоног хугацаа хоцроосон байна.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах талаар албан шаардлага өгөв.

2.8.1.2 Франц улсын иргэнээс тус сургуулийн сурагчид өгсөн хандивыг сургуулийн засварт хэрэглэсэн ба орлого, зарлагын бүртгэлд тусгаагүй, өглөг үүсгээгүй байна.

Энэ нь үнэн зөв байх, бодитой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна

Шийдвэрлэсэн: Тухайн сурагчийг хохиролгүй болгох, хандив, бэлэг тусламжийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгах талаар албан шаардлага өгөв.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Илүү цагийг тооцоолол, хөрөнгө, бараа материалын тооллогод анхаарал хандуулан дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Ерөнхий боловсролын 29 дүгээр тусгай сургуулийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 2,081,661.7 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 2,031,682.3 мянган төгрөг буюу 97.5 хувьтай байна.

Хүүхдийн өдөр тутамын ирцээс хамааран үдийн цай хөтөлбөрийн 48,213.0 мянган төгрөгийн хэмнэлт үүсч төсөвт төвлөрүүлсэн.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Ерөнхий боловсролын 29 дүгээр сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, 118 баримт хугацаанд нь оруулж, 18 баримт хугацаа хоцроон оруулсан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулж 4 алдаа, зөрчил илэрснээс 2 асуудалд залруулга, 1 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлсэн байна. Үүнтэй холбоотойгоор зөвлөмж, албан шаардлагын биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 50 хувьтай байна.

Энэ нь НДШ-ийн зардлыг дутуу тайлагнасанд зөвлөмж өгснийг хэрэгжүүлсэн эсэх талаар Нийслэлийн аудитын газарт хариу ирүүлээгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Ерөнхий боловсролын 29 дүгээр тусгай сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Ерөнхий боловсролын 29 дүгээр тусгай сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Ерөнхий боловсролын 29 дүгээр тусгай сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой

1.1 Илрүүлэлт:

Бараа материалын тайланд үндсэн хөрөнгийн шинж чанартай 3,721.5 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэсэн байна.

1.2 Эрсдэл:

Энэ нь үнэн зөв байх, бодитой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтыг зөрчсөн байна.

1.3 Шийдвэрлэсэн:

Аудитын явцад Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөв.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгсөн зөвлөмжийг зөвшөөрч биелүүлж ажиллана.

2. Дотоод хяналттай холбоотой

2.1 Илрүүлэлт:

Хөрөнгийн тооллогын тооцоо бодсон акт, илтгэх хуудас үйлдээгүй, тооллогын комиссын дарга, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулаагүй. Мөн тооллогын комисс томилохдоо комиссын ахлагчаар ерөнхий нягтлан бодогчийг томилсон байна.

2.2 Эрсдэл:

Энэ нь үнэн зөв байх, бодитой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна, ТБОНӨТХуулийн 73 дугаар зүйлийн 2 дахь заалт "байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж

дансны үлдэгдлийг тулган шалгана", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх заалт "тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2.3 Шийдвэрлэсэн:

Аудитын явцад холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөв.

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгсөн зөвлөмжийг зөвшөөрч биелүүлж ажиллана.

3. Балансын данстай холбоотой

3.1 Илрүүлэлт:

Бараа материалын тайланд үндсэн хөрөнгийн шинж чанартай тавилга эд хогшлыг бүртгэж Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэргүй, чанар байдлыг тодорхойлсон нотлох баримтгүй хөрөнгийг 2018 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн Ерөнхий боловсролын 29 дүгээр тусгай сургуулийн захирлын А-28 тоот тушаалаар 6 нэр төрлийн хөрөнгө акталсан.

3.2 Эрсдэл:

Энэ нь үнэн зөв байх, бодитой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 02 дугаар сарын 14-ийн өдрийн 86 дугаар тогтоолыг зөрчсөн байна.

3.3 Шийдвэрлэсэн:

Аудитын явцад холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөв

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгсөн зөвлөмжийг зөвшөөрч биелүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 30-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>61,048,197.58</u>	<u>66,971,083.45</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	61,048,197.58	66,971,083.45
351	Түүхий эд материал	9,570,851.15	14,441,931.15
35110	Тусгай зориулалттай материал	274,498.00	274,498.00
35130	Эм боох материал	9,296,353.15	14,167,433.15
354	Хангамжийн материал	51,477,346.43	52,529,152.30
35410	Бичиг хэргийн материал	297,610.00	1,256,700.00
35420	Аж ахуйн материал	1,921,850.00	8,457,100.00
35440	Түлш, шатах тослох материал	317,220.00	3,652,720.00
35450	Барилгын засварын материал	1,206,500.00	4,661,350.00
35460	Хүнсний материал	3,916,807.90	3,584,269.60
35470	Бусад хангамжийн материал	43,817,358.53	30,917,012.70
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,406,596,077.96</u>	<u>4,905,020,366.80</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,406,596,077.96	4,905,020,366.80
392	Биет хөрөнгө	1,406,596,077.96	4,359,556,046.80
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,763,323,482.00	4,082,676,048.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-676,052,621.29	-69,939,600.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	126,974,891.00	126,974,891.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-34,159,495.97	-39,421,959.05
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	567,465,491.70	515,427,768.22
39206	Хуримтлагдсан элэгдэл	-414,682,449.70	-340,594,880.86
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	210,272,269.27	173,776,182.47
39208	Хуримтлагдсан элэгдэл	-153,991,787.74	-122,744,874.83
39214	Бусад үндсэн хөрөнгө	121,539,300.00	98,746,354.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	-120,458,356.76	-85,100,000.00
39217	Ном	16,365,355.45	19,756,117.45
393	Биет бус хөрөнгө	00.00	545,464,320.00
39301	Програм хангамж	1,540,000.00	1,540,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,540,000.00	-1,540,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	545,464,320.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,467,644,275.54</u>	<u>4,971,991,450.25</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>00.00</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,467,644,275.54</u>	<u>4,971,991,450.25</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,467,644,275.54	4,971,991,450.25
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,222,191,527.77	2,767,655,847.77
51101	Өмч: - төрийн	2,222,191,527.77	2,767,655,847.77
512	Хуримтлагдсан үр дүн	-826,970,782.71	-833,228,973.87
51210	Өмнөх үеийн үр дүн	-826,970,782.71	-826,423,446.97
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-6,805,526.90
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	00.00	00.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	72,423,530.48	3,037,564,576.34

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,963,442,925.00	2,157,843,013.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	30,462,140.00	39,313,113.00
120	Нийтлэг татварын бус орлого	28,745,540.00	39,313,113.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	28,745,540.00	39,313,113.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	450,000.00	27,451.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	28,295,540.00	39,285,662.00
122	Тусламжийн орлого	1,716,600.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	1,716,600.00	00.00
122002	Хандив тусламж /гадаад/	00.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	42,866,585.00	2,118,529,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	2,079,862,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	2,079,862,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,890,114,200.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	42,866,585.00	38,667,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,866,585.00	38,667,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,971,793,725.94	2,163,633,985.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,971,793,725.94	2,163,633,985.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,813,782,032.19	2,115,420,946.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,304,130,527.86	1,451,299,625.71
210101	Үндсэн цалин	1,304,130,527.86	1,451,299,625.71
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	140,402,993.75	167,188,134.68
210201	Тэтгэврийн даатгал	92,047,236.70	115,805,533.47
210202	Тэтгэмжийн даатгал	11,017,895.30	13,526,040.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,332,399.06	12,196,764.65
210204	Ажилгүйдлийн даатгал	2,678,392.81	2,417,128.31
210205	Эрүүл мэндийн даатгал	22,327,069.88	23,242,667.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	90,036,626.84	104,635,361.87
210301	Гэрэл, цахилгаан	30,692,495.00	32,768,410.00
210302	Түлш, халаалт	39,597,753.00	38,815,354.00
210303	Цэвэр, бохир ус	19,746,378.84	33,051,597.87
2104	Хангамж, бараа материалын зардал	35,391,511.00	74,575,653.63
210401	Бичиг хэрэг	3,174,660.00	7,687,250.00
210402	Тээвэр, шатахуун	6,752,300.00	10,984,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,765,050.00	3,246,300.00
210404	Ном, хэвлэл	48,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,269,720.00	6,250,240.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,381,781.00	19,119,430.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	00.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	27,287,733.63
2105	Нормативт зардал	136,241,455.10	149,531,718.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,569,480.00	5,732,900.00
210502	Хоол, хүнс	128,780,975.10	140,508,918.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,891,000.00	3,289,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,935,100.00	26,406,650.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	538,700.00	00.00
210604	Урсгал засвар	6,396,400.00	26,406,650.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,063,872.00	34,810,820.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,672,472.00	34,419,420.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	391,400.00	391,400.00

Ерөнхий боловсролын 29 дүгээр тусгай сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	89,579,945.64	106,972,982.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,400.00	304,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,901,300.00	10,558,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	86,664,245.64	96,109,682.57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	158,011,693.75	48,213,038.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	157,983,549.04	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	439,149.20	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	116,129,400.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	41,414,999.84	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,144.71	48,213,038.74
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,144.71	48,213,038.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-8,350,800.94	-5,790,972.70
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	1,014,554.20
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	1,014,554.20
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-1,014,554.20
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-8,350,800.94	-6,805,526.90

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,895,651,272.00	2,118,557,351.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	450,000.00	27,451.00
120	Нийтлэг татварын бус орлого	450,000.00	27,451.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	450,000.00	27,451.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	450,000.00	27,451.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,895,201,272.00	2,118,529,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	2,079,862,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	2,079,862,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,890,114,200.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,087,072.00	38,667,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,087,072.00	38,667,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,889,827,272.00	2,086,036,351.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,889,827,272.00	2,086,036,351.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,675,475,127.29	1,949,133,132.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,303,925,499.66	1,450,990,025.67
210101	Үндсэн цалин	1,238,437,815.66	972,712,225.67
210102	Нэмэгдэл	00.00	359,477,800.00
210104	Урамшуулал	65,487,684.00	118,800,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	140,608,021.79	167,497,734.72
210201	Тэтгэврийн даатгал	140,608,021.79	159,456,740.12
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	2,009,042.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	1,606,268.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	400,360.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	4,025,324.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	90,036,626.84	104,635,361.87
210301	Гэрэл, цахилгаан	30,692,495.00	32,768,410.00
210302	Түлш, халаалт	39,597,753.00	38,815,354.00
210303	Цэвэр, бохир ус	19,746,378.84	33,051,597.87
2104	Хангамж, бараа материалын зардал	29,635,057.00	61,710,560.00
210401	Бичиг хэрэг	3,206,900.00	8,794,440.00
210402	Тээвэр, шатахуун	6,760,300.00	14,040,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,765,050.00	3,246,300.00
210404	Ном, хэвлэл	3,748,600.00	2,719,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,245,720.00	6,736,240.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,908,487.00	26,173,880.00
2105	Нормативт зардал	87,390,250.00	79,453,730.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,905,580.00	16,822,880.00
210502	Хоол, хүнс	75,193,670.00	44,973,580.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,291,000.00	17,657,270.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,836,300.00	25,107,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	538,700.00	00.00
210604	Урсгал засвар	5,297,600.00	25,107,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,213,872.00	41,665,920.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,822,472.00	41,274,520.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	391,400.00	391,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,829,500.00	18,072,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	760,500.00	760,500.00

Ерөнхий боловсролын 29 дүгээр тусгай сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,069,000.00	17,311,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	214,352,144.71	136,903,218.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	214,324,000.00	88,690,180.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	56,779,600.00	88,690,180.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	116,129,400.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	41,415,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,144.71	48,213,038.74
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,144.71	48,213,038.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>5,824,000.00</u>	<u>32,521,000.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,824,000.00	32,521,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,824,000.00	32,521,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,824,000.00	32,521,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,824,000.00	32,521,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-5,824,000.00</u>	<u>-32,521,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан /төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2017 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	2,222,191,527.77	72,423,530.48	-818,619,981.77	1,475,995,076.48
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,222,191,527.77	72,423,530.48	-818,619,981.77	1,475,995,076.48
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-8,350,800.94	-8,350,800.94
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,222,191,527.77	72,423,530.48	-826,970,782.71	1,467,644,275.54
2018 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	2,222,191,527.77	72,423,530.48	-826,970,782.71	1,467,644,275.54
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	547,335.75	547,335.75
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,222,191,527.77	72,423,530.48	-826,423,446.96	1,468,191,611.29
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	545,464,320.00	2,965,141,045.86	00.00	3,510,605,365.86
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн		00.00	-6,805,526.90	-6,805,526.90
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,767,655,847.77	3,037,564,576.34	-833,228,973.86	4,971,991,450.25

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,081,661,700.00	2,031,682,312.26	49,979,387.74	97.6%
УРСГАЛ ЗАРДАЛ	2,081,661,700.00	2,031,682,312.26	49,979,387.74	97.6%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,991,573,900.00	1,942,992,132.26	48,581,767.74	97.6%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,420,406,400.00	1,423,150,025.67	-2,743,625.67	100.2%
Үндсэн цалин	969,968,600.00	972,712,225.67	-2,743,625.67	100.3%
Нэмэгдэл	331,637,800.00	331,637,800.00	00.00	100%
Урамшуулал	118,800,000.00	118,800,000.00	00.00	100%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	170,489,400.00	167,497,734.72	2,991,665.28	98.2%
Тэтгэврийн даатгал	115,803,100.00	159,456,740.12	-43,653,640.12	137.7%
Тэтгэмжийн даатгал	13,671,500.00	2,009,042.00	11,662,458.00	14.7%
ҮОМШӨ-ний даатгал	10,937,500.00	1,606,268.00	9,331,232.00	14.7%
Ажилгүйдлийн даатгал	2,734,000.00	400,360.00	2,333,640.00	14.6%
Эрүүл мэндийн даатгал	27,343,300.00	4,025,324.60	23,317,975.40	14.7%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	108,967,500.00	104,635,361.87	4,332,138.13	96.0%
Гэрэл, цахилгаан	32,300,000.00	32,768,410.00	-468,410.00	101.5%
Түлш, халаалт	43,567,500.00	38,815,354.00	4,752,146.00	89.1%
Цэвэр, бохир ус	33,100,000.00	33,051,597.87	48,402.13	99.9%
Байрны түрээс	00.00	00.00	00.00	0.0%
Хангамж, бараа материалын зардал	63,769,000.00	61,710,560.00	2,058,440.00	96.8%
Бичиг хэрэг	9,201,400.00	8,794,440.00	406,960.00	95.6%
Тээвэр, шатахуун	14,040,200.00	14,040,200.00	00.00	100.0%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,246,300.00	3,246,300.00	00.00	100.0%
Ном, хэвлэл	4,065,900.00	2,719,500.00	1,346,400.00	66.9%
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,385,100.00	6,736,240.00	648,860.00	91.2%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	25,830,100.00	26,173,880.00	-343,780.00	101.3%
Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	00.00	00.00	0.0%
Нормативт зардал	124,719,300.00	83,016,230.00	41,703,070.00	66.6%
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,300,000.00	20,385,380.00	-85,380.00	100.4%
Хоол, хүнс	86,711,900.00	44,973,580.00	41,738,320.00	51.9%
Нормын хувцас, зөөлөн эдлэл	17,707,400.00	17,657,270.00	50,130.00	99.7%
Эд хогшил, урсгал засварын зардал	54,071,300.00	54,066,100.00	5,200.00	100.0%

Ерөнхий боловсролын 29 дүгээр тусгай сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Багаж, техник, хэрэгсэл	27,538,700.00	28,958,500.00	-1,419,800.00	105.2%
Урсгал засвар	26,532,600.00	25,107,600.00	1,425,000.00	94.6%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,887,400.00	30,843,920.00	43,480.00	99.9%
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,496,000.00	30,452,520.00	43,480.00	99.9%
Тээврийн хэрэгслийн татвар	391,400.00	391,400.00	00.00	100.0%
Бараа үйлчилгээний бусад зардал	18263600.00	18072200.00	191,400.00	99.0%
Бараа үйлчилгээний бусад зардал	760,500.00	760,500.00	00.00	100.0%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,503,100.00	17,311,700.00	191,400.00	98.9%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	90087800.00	88690180.00	1,397,620.00	98.4%
Бусад урсгал шилжүүлэг	90,087,800.00	88,690,180.00	1,397,620.00	98.4%
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	90,087,800.00	88,690,180.00	1,397,620.00	98.4%
Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	00.00	00.00	00.00	0.0%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,081,662,300.00	2,031,682,312.26	49,979,987.74	97.6%
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,079,862,300.00	2,031,654,861.26	48,207,438.74	97.7%
Улсын төсвөөс санхүүжих	2,079,862,300.00	2,031,654,861.26	48,207,438.74	97.7%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	00.00	0%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	00.00	0%

4.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан /төгрөг/

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		38,662,000.00	-38,662,000.00	
УРСГАЛ ЗАРДАЛ		38,662,000.00	-38,662,000.00	
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		38,662,000.00	-38,662,000.00	
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		27,840,000.00	-27,840,000.00	
Үндсэн цалин		00.00	00.00	
Нэмэгдэл		27,840,000.00	-27,840,000.00	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		10,822,000.00	-10,822,000.00	
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		10,822,000.00	-10,822,000.00	
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		00.00	00.00	
Даатгалын үйлчилгээ		00.00	00.00	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		38,662,000.00	-38,662,000.00	
НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		38,662,000.00	-38,662,000.00	
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан мөнгө		38,662,000.00	-38,662,000.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		00.00	00.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		00.00	00.00	
АЖИЛЛАГСАДЫН ТОО		140.00	00.00	
Удирдах ажилтан		01.00	00.00	
Гүйцэтгэх ажилтан		78.00	00.00	
Үйлчлэх ажилтан		61.00	00.00	
Гэрээт ажилтан		00.00	00.00	

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:

2019 он

Аудитын нэр:

Ерөнхий боловсролын 29 дүгээр тусгай сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код:

САГ-2019/142/СТА-ТШЗ

Шалгагдсан байгууллагын

Ерөнхий боловсролын 29 дүгээр тусгай сургууль

мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Тайлангийн хугацаа хоцроосон	-	Албан шаардлага өгөх	Нягтлан бодогч	Б. Алтантуяа
2	Франц улсын иргэнээс тус сургуулийн сурагчид өгсөн хандивыг сургуулийн засварт хэрэглэсэн ба орлого, зарлагын бүртгэлд тусгаагүй, өглөг үүсгээгүй байна.	1,606.00	Албан шаардлага өгөх	Үүрэг гүйцэтгэгч Нягтлан бодогч	М. Сарантуяа Б. Алтантуяа
3	Бараа материалын тайланд үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгө бүртгэсэн байна	1,121.90	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Б. Алтантуяа
4	Хөрөнгийн тооллогын тооцоо бодсон акт, илтгэх хуудас үйлдээгүй, тооллогын комиссын дарга, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулаагүй. Мөн тооллогын комисс томилохдоо комиссын ахлагчаар ерөнхий нягтлан бодогчийг томилсон байна.	-	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Б. Алтантуяа
5	Бараа материалын тайланд үндсэн хөрөнгийн шинж чанартай тавилга эд хогшлыг бүртгэж Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэргүй, чанар байдлыг тодорхойлсон нотлох баримтгүй хөрөнгийг 2018 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн Ерөнхий боловсролын 29 дүгээр тусгай сургуулийн захирлын А-28 тоот тушаалаар 6 нэр төрлийн хөрөнгө акталсан	2,597.60	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Б. Алтантуяа
	Дүн	5,327.50			

